



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчийг хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон 13 нэрийн нийт 118,197,703.43 (нэг зуун арван найман сая нэг зуун ерэн долоон мянга долоон зуун гурван төгрөг дөчин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярцогт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг зориулалтын дагуу нөхөн сэргээж ашиглах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4 Арга хэмжээний биелэлтийн хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000151

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 4 дугаар сарын 2-ны өдрийн
158 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг
1	Гантээрэм дэд станцын барилга	1975-12-28	1	47,082,810.90	47,082,810.90	-
2	Хархорин 35/0.4кВ-ын НС-1 ТП-1	1986-12-20	1	4,522,500.00	4,522,500.00	-
3	Трансформатор ТМ-40	1991-01-30	1	5,620,000.00	5,620,000.00	-
4	Трансформатор ТМ-100	1995-01-30	1	5,000,000.00	5,000,000.00	-
5	Трансформатор ТМ-63	1998-01-30	1	4,400,000.00	4,400,000.00	-
6	Хуурай салгуур 35кВ	2005-06-01	1	4,169,200.00	4,169,200.00	-
7	Кабелийн гэмтэл илрүүлэгч багаж	2012.12.28	1	9,800,000.00	9,800,000.00	-
8	Хэмжих хэрэгслийн стэнд	2001.01.30	1	15,195,600.10	15,195,600.10	-
9	Реле хамгаалалтын шалгах багаж	1997-12-20	1	687,400.00	687,400.00	-
10	Туршилтын аппарат	2005-12-20	1	536,000.00	536,000.00	-
11	Тоолуурын стэнд	2003-12-20	1	7,715,100.00	7,715,100.00	-
12	1 Фазын тоолуур шалгах багаж	2008-12-20	1	2,560,000.00	2,560,000.00	-
13	3 Фазын этолон төхөөрөмж SB2300	2009-01-30	1	10,909,092.43	10,909,092.43	-
Нийт дүн				118,197,703.43	118,197,703.43	-
				(нэг зуун арван найман сая нэг зуун ерэн долоон мянга долоон зуун гурван төгрөг дөчин гурван мөнгө)		-